



Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн 2026 оны 2-р улиралд хийсэн ажлын товч тайлан

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7.а -д заасан чиг үүргийн хүрээнд радио, телевизээр хүүхдэд зохисгүй агуулга нэвтрүүлсэн талаарх гомдол болон 18+ насны ангилалтай кино, бүтээлийг цагийн хязгаарлалт зөрчиж нэвтрүүлсэн хяналт мониторингийн дүнг Харилцаа холбооны зохицуулах хорооны дэргэдэх Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах орон тооны бус зөвлөлийн хурлаар хэлэлцдэг.

2026 оны II улиралд

1. 18+ насны ангиллын кино, контентыг цагийн хязгаарлалт зөрчин нэвтрүүлсэн зөрчил, насны ангиллын зохицуулалтын хэрэгжилт.

2026 оны II улиралд телевизүүдийн хөтөлбөрт хийсэн хяналт, мониторингоор 18+ насны ангиллын кино, бүтээлийг цагийн хязгаарлалт зөрчин нэвтрүүлсэн 2 телевизийн (25 дугаар суваг телевиз, Хөгжил телевиз) зөрчил илэрч, бүртгэгдсэн.

Хяналт, мониторингийн дүнгээр дээрх телевизүүд 18+ насны ангиллын кино, бүтээлийг 22:00 цагаас өмнө нэвтрүүлсэн нь цагийн хязгаарлалтын шаардлагыг зөрчсөн болох нь тогтоогдсон. Харин тухайн кино, бүтээлийн агуулгыг Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага болон "Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм"-ийн хүрээнд хянан үзэхэд дүрмээр хязгаарласан бусад зохисгүй агуулга илрээгүй.

Насны ангиллын зохицуулалтаас үүдэлтэй практик хүндрэл. Илэрсэн зөрчлийн талаар холбогдох телевизүүдээс тайлбар авахад тухайн кино, бүтээл нь агуулгын хувьд 16+ насны ангилалд илүү нийцэх боловч Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй **"Өргөн нэвтрүүлэгт насны ангилал тогтоох таних тэмдэг ашиглах шаардлага"** MNS 6587 стандартад 16+ насны ангилал тусгагдаагүй тул 18+ ангиллаар тэмдэглэн нэвтрүүлсэн гэж тайлбарласан. Мөн тухайн бүтээл нь 12+ ангилалд хамруулах боломжгүй гэж үзсэн байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд зарим кино, бүтээлийн агуулга нь 12+ насны ангилалд нийцэхгүй боловч стандартаар 16+ ангилал байхгүйгээс 18+ ангиллаар нэвтрүүлэх шаардлага үүсдэг тохиолдол гарч байна. Үүний улмаас 18+ ангиллын контентыг цагийн хязгаарлалт зөрчин нэвтрүүлэх зөрчил давтан бүртгэгдэж байгаа бөгөөд насны ангиллын өнөөгийн тогтолцоо нь кино, бүтээлийн агуулгыг насны онцлогт нийцүүлэн ангилж, нэвтрүүлэхэд хүндрэл учруулж байна.

Хэрэгжүүлж буй арга хэмжээ. Иймд насны ангиллын үндэсний стандартыг шинэчлэхээр санал гарган ажиллаж байна. Түүнчлэн Кино урлагийг дэмжих тухай хууль болон өргөн

нэвтрүүлгийн салбарын насны ангиллын зохицуулалтын уялдаа холбоог боловсронгуй болгох, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар эрх бүхий байгууллагуудад санал, мэдээлэл хүргүүлэх чиглэлээр ажиллаж байна.

2. Зохисгүй агуулга нэвтрүүлсэнтэй холбоотой иргэдээс ирүүлсэн гомдол, шийдвэрлэлийн талаар.

2026 оны II улиралд ФМ 88.3 радиогоор нэвтрүүлсэн "Унтлагын өрөө" нэвтрүүлгээр хүүхдэд зохисгүй агуулга нэвтрүүлсэн гэх үндэслэлээр иргэдээс 2 гомдол ирүүлсэн.

Гомдлын дагуу тухайн нэвтрүүлгийг Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага болон "Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм"-ийн хүрээнд хянан үзэхэд 18+ насны ангилалтай контентыг 22:00 цагаас хойш нэвтрүүлсэн нь цагийн хязгаарлалтын шаардлагыг зөрчөөгүй боловч нэвтрүүлгийн зарим агуулга нь дээрх дүрмээр хязгаарласан зохисгүй агуулгад хамаарах үндэслэлтэй гэж үзсэн. Иймд тухайн радиод гомдлыг уламжилж, албан ёсны тайлбар ирүүлэхийг мэдэгдсэн.

Тус радиогоос ирүүлсэн тайлбартаа нэвтрүүлэг нь насанд хүрэгчдэд бэлгийн боловсрол, гэр бүл, хосын харилцааны талаар боловсролын шинжтэй мэдээлэл хүргэх зорилготой байсан боловч шууд харилцах хэсгийн явцад зохисгүй үг хэллэг хэрэглэгдэж, анхны зорилгоос хазайх эрсдэлтэй болохыг хүлээн зөвшөөрч, тухайн хэлбэрээр нэвтрүүлэхээ зогсоосон талаар мэдэгдсэн. Цаашид нэвтрүүлгийн агуулга, хэлбэрийг өөрчилж, гэр бүл, хосын харилцаа, эрүүл хандлага, ёс зүйтэй харилцааны талаарх мэдлэг, мэдээлэл олгох, соён гэгээрүүлэх, боловсролын чиглэлээр редакцын илүү хяналттай байдлаар бэлтгэн хүргэх арга хэмжээ авахаа илэрхийлсэн.

Авсан арга хэмжээ, хяналтын дүн болон радиогоос ирүүлсэн тайлбарын талаар гомдол гаргагчдад албан ёсоор мэдэгдэн, гомдлыг шийдвэрлэсэн.

3. Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаа:

Тайлант хугацаанд Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн А/86 дугаар тушаалын хавсралаар баталсан "Орон тооны бус зөвлөлийн ажиллах журам"-ын 2.2.1-д заасан үндэслэлээр зөвлөлөөр хэлэлцэн дүгнэлт гаргах шаардлагатай эргэлзээтэй, маргаантай асуудал, мөн дүрэмд тусгагдаагүй агуулгатай холбоотой гомдол бүртгэгдээгүй тул зөвлөлийн хуралдаан биетээр зохион байгуулаагүй болно.

Үүнтэй холбогдуулан зөвлөлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, тайлант хугацаанд хийгдсэн хяналт, мониторингийн үр дүн болон холбогдох мэдээллийг зөвлөлийн гишүүдэд цахим шуудангаар хүргүүлэн танилцуулсан. Үүнд:

- Телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүнгээр илэрсэн 18+ насны ангиллын контентыг цагийн хязгаарлалт зөрчин нэвтрүүлсэн зөрчлийн талаарх мэдээлэл, тайлан;
- 2026 оны II улиралд өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын мэдээлэл.

4. Орон тооны бус зөвлөлөөс хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлыг хэрэгжүүлэв.

- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан “Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зөвлөмж”-ийг боловсруулсан.
- Тус зөвлөмжийг Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудсанд нийтлэн, үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн. (Нийтэлсэн холбоос: <https://sl1nk.com/ix5q8dp>)

Телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүнгээр илэрсэн 18+ насны ангиллын контентыг цагийн хязгаарлалт зөрчин нэвтрүүлсэн зөрчлийн мэдээлэл

(Хөтөлбөрийн 2026 оны 2-4 сарын хяналт, *мониторингийн* тайлангаас)

Орон тооны бус зөвлөлийн 2026 оны 1-р улирлын ээлжит (2026.03.17-ны өдөр) хуралдаанаар радио, телевизээр хүүхдэд зохисгүй агуулга нэвтрүүлсэнтэй холбоотой иргэдийн гомдол, мөн 18+ насны ангилалтай кино, бүтээлийг цагийн хязгаарлалт зөрчин нэвтрүүлсэнтэй холбоотой 2025 оны 11, 12 дугаар сар болон 2026 оны 1 дүгээр сарын хяналт, мониторингийн дүнгээр илэрсэн зөрчлүүдийг хэлэлцсэн. Хуралдааны шийдвэрийн дагуу холбогдох телевизүүдэд зөвлөмж, мэдэгдэл хүргүүлж, олон нийтэд мэдээлэх зэрэг арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна.

Зөвлөлийн 1-р улирлын хуралдаанаас хойш буюу 2026 оны 2-4 дүгээр саруудад телевизүүдийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүнгээр 18+ насны ангиллын контентыг 06:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлсэн дараах цагийн хязгаарлалтын зөрчлүүд бүртгэгдсэн (зохисгүй агуулга илрээгүй). Үүнд:

- 2 дугаар сар: Хөгжил-1 удаа
- 3 дугаар сар: 25-р суваг-20 удаа
- 4 дүгээр сар: 25-р суваг-26 удаа, Хөгжил-1 удаа


2026 оны 2-4 дүгээр сарын мониторингийн дүн

Тв нэр	2-р сар	3-р сар	4-р сар	Нийт
25-р суваг	0	20	26	46
Хөгжил телевиз	1	0	1	2
Нийт зөрчлийн тоо	1	20	27	48

Тайлант хугацаанд бүртгэгдсэн зөрчлүүдийг авч үзэхэд агуулгын хувьд 18+ насны ангилалд хамаарах зохисгүй контент нэвтрүүлсэн зөрчил илрээгүй. Харин бүртгэгдсэн зөрчлүүд нь 16+ насны ангилал үндэсний стандартад тусгагдаагүйгээс зарим кино, бүтээлийг 18+ ангиллаар нэвтрүүлж, улмаар цагийн хязгаарлалтын шаардлага зөрчигдсэнтэй холбоотой байна.

Сүүлийн таван жилийн хяналт, мониторингийн дүнгээр 18+ насны ангиллын кино, бүтээлийн цагийн хязгаарлалтын зөрчлийн тоо ерөнхийдөө буурсан байна.

График: Телевизүүдийн 18+ насны ангилалтай кино, нэвтрүүлгийн цагийн хязгаарлалт зөрчсөн зөрчлийн тоо



2026.6.25

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР